



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2017. 05. 05 № 06

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД
Ж.БАТСУУРЬ ТАНАА

Асуулт тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь танд дараах асуултыг тавьж байна.

Сургалтын төрийн сангийн чиг үүргийг өргөжүүлж, “Боловсролын зээлийн сан” болгон өөрчлөн зохион байгуулж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэсний үндсэн дээр Оюутны хөгжлийн зээлийг олгохоор болсон билээ. Оюутны хөгжлийн зээл нь Монгол улсын магадлан итгэмжлэгдсэн төрийн болон төрийн бус өмчийн бүх их, дээд сургууль, коллежийн оюутан бүрт нээлттэй байх ба Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Оюутны хөгжлийн зээлийн журам”-д “зээлийн эргэн төлөлт нь оюутны ирээдүйн орлогод суурилах” гэж заасан байдаг. Тодруулж хэлбэл, “Оюутны хөгжлийн зээл” -д оролцогч банкнаас зээл хүссэн оюутанд орлого баталгаажуулахтай холбогдсон, орлого болон хөрөнгийн барьцаа баталгаа гэх мэт нэмэлт шаардлага тавихгүйгээр зээлийг олгох ёстой гэж ойлгож, иргэд хөдөлмөрчдөд таниулж ирсэн.

Гэтэл Ховд аймгийн иргэд, хөдөлмөрчдөөс “Оюутны хөгжлийн зээл”-д барьцаалах хөрөнгө, орлогогүй улмаас хамрагдах боломжгүй байна гэсэн гомдол сүүлийн үед их ирж байна. “Оюутны хөгжлийн зээл”-д оролцогч банкнаас зөвхөн ХААН, Төрийн банкууд сумдад үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд эдгээр банкууд дараах нэмэлт шаардлагыг тавьдаг байна. ХААН банкны хувьд зээл хүссэн оюутан, эсвэл түүний хамтран зээлдэгч нь “циалигийн орлоготой, эсвэл сүүлийн 6-н сард тус банкны дансаар дамжуулсан бизнесийн орлоготой, тэтгэврийн орлоготой, тэр нь зээлгүй байх, болон эсвэл 100 хонин толгойд шилжүүлсэн мал барьцаалах” гэж байхад Төрийн банкны хувьд зээл хүссэн оюутан, эсвэл түүний хамтран зээлдэгч нь “барьцаа хөрөнгө, орлоготой байх” гэсэн нэмэлт шаардлагуудыг тавьж байна.

“Оюутны хөгжлийн зээл”-ийн журмыг оролцогч банкууд зөрчөөд байна уу, эсвэл “Оюутны хөгжлийн зээл” нь зөвхөн барьцаалах хөрөнгө, орлоготой оюутанд нээлттэй юм уу гэдэг асуултанд хариулт өгнө үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан 14 хоногийн хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Байнгын хорооны хуралдаанд сонсгохыг таниас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

О.БАТНАСАН

